



МОНГОЛ УЛС
САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ
ТОГТООЛ

2010 оны 10 сарын 27 өдөр

Дугаар 329

Улаанбаатар хот

Г “Кибернетик ББСБ” ХХК-ийн банк бус санхүүгийн Ү
гадаад валютын арилжааны үйл ажиллагаа эрхлэх
тусгай зөвшөөрлийг хүчингүй болгох тухай

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6.1.3, Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 10.1.5, 14.1.1, Санхүүгийн зохицуулах хорооны 2008 оны 186 дугаар тогтоолоор батлагдсан “Банк бус санхүүгийн үйл ажиллагааны зохицуулалтын журам”-ын 10.4.1 дэх заалтыг тус тус үндэслэн Санхүүгийн зохицуулах хорооноос ТОГТООХ нь:

1. “Кибернетик ББСБ” ХХК-ийн банк бус санхүүгийн гадаад валютын арилжааны үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг хүчингүй болгосугай.

2. Улсын бүртгэлийн гэрчилгээ болон тусгай зөвшөөрлийн гэрчилгээнд холбогдох тэмдэглэгээг 2010 оны 11 дүгээр сарын 10-ны өдрийн дотор хийлгэхийг “Кибернетик ББСБ” ХХК /Б.Бадамгарав/-д үүрэг болгосугай.

3. Тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Бичил санхүүгийн газар /Н.Оюунчимэг/, олон нийтэд мэдээлэхийг Тамгын газар /Н.Удаанжаргал/-т тус тус даалгасугай.

ДАРГА

Д.БАЯРСАЙХАН